



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/469

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд нутгийнхаа хөгжил цэцэглэлтийн төлөө өөрийн оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулан орон нутгийнхаа хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан ажилласан хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 150 000 төгрөг /нэг зуун тавин мянга/-ийг зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээнд зарцуулах 150 000 төгрөг /нэг зуун тавин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 10-ны өдрийн
А/469 дүгээр захирамжийн хавсралт



2001 ОНЫ ТӨГСӨГЧДИЙН 20 ЖИЛИЙН ОЙН ТОХИОЛДУУЛАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

Д/д	Нэр	Албан тушаал
1	Б.Одонтуяа	2001 оны төгсөгч
2	Б.Золзаяа	2001 оны төгсөгч
3	О.Мөнхцэцэг	2001 оны төгсөгч
4	Б.Бат-Ерөөлт	2001 оны төгсөгч
5	Б.Батзориг	2001 оны төгсөгч

-oOo-